

С И Т И У Н И ВЕРСИТИ

2024 оны XI сар

77442244

info@citi.edu.mn

www.citi.edu.mn

CITI University

NEWS

- “БИДНИЙ БАХАРХАЛ”
- “ОЮУТНЫ ТАЛБАР”
- “СИТИ БРЭНД”
- “CONGRATULATIONS”
- “СИТИ СПОРТ”
- “МАНАЙ БАГШ”
- “НОМ ЯРЬЖ ӨГЪЕ”
- “СИТИ NEWS”
- “АМЖИЛТЫН ТҮҮХ”

“БИДНИЙ БАХАРХАЛ”

Б.МАРГАД: СУРГУУЛИАС БИДЭНД БҮХ ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГИЙГ ҮЗҮҮЛДЭГ

“СИТИ” Их сургуулийн Маркетингийн III курсийн оюутан, “АЯНГА” багийн гишүүн Б.Маргадтай ярилцлаа.

Тэрээр Монголын оюутны лигийн 2023-2024 оны тэмцээний финалын үнэ цэнэтэй тоглогч /FINALS MVP/-оор шалгарсан билээ.

-Оюутны лигийн тоглолтууд хэрхэн өрнөж байна вэ?

-Энэ жил бидний хувьд маш ширүүн өрсөлдөөнтэй улирал болж байна. Лигийн багууд бүгд л хүчтэй учраас бид бүх хүчээ гаргаж тоглохыг хичээж байна. Бид багийн бүрэлдэхүүн, дасгалжуулалт, сэтгэл зүйдээ их анхаарал хандуулж байгаа.

-Сагсан бөмбөгт хэзээнээс дурлах болсон бэ?

-Багаасаа л NBA тоглолтуудыг шимтэн үздэг байлаа. Зургадугаар ангиасаа эхлэн Сүхбаатар аймагтаа Хасхүү багшийн удирдлаган дор бэлтгэл хийж эхэлсэн. 12 дугаар ангиа төгсөөд шууд л “СИТИ” Их сургуульд элсэж, нэгдүгээр курсдээ сонгон шалгаруулалтад тэнцэн “АЯНГА” багийн гишүүн болсон. Сургуулийнхаа лигт тоглох болсон



нь миний хувьд маш том боломж байсан.

-“АЯНГА” багийн гишүүнээр

орсноор чамд ямар боломжууд нээгдсэн бэ?

Төгсгөл нь III нүүрт >>

“МАНАЙ БАГШ”

Ц.МӨНХДЭЛГЭР: ОЮУТНЫ ЧАНАРЫГ ИЛҮҮД ҮЗЭЖ, ЧАДВАРЛАГ БОЛОВСОН ХҮЧИН БЭЛТГЭХИЙГ ЧУХАЛЧИЛДАГ

“СИТИ” Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор Ц.Мөнхдэлгэртэй ярилцлаа.

-“СИТИ” Их сургуулийн Хууль зүйн сургуулийг сонгож суралцаанаараа ямар давуу талтай талаар ярилцлагаа эхэлбэ?

-“СИТИ” Их сургуулийн Хууль зүйн сургууль нь Монголын нэрт хуульчдын нэг, гавьяат хуульч Д.Дэмбэрэлцэрэн агсны нэрэмжит сургууль. Д.Дэмбэрэлцэрэн агсан Монголын хууль зүйн салбарт хүчин зүтгэж, амьдралаа зориулсан хүн л дээ. Түүний үүсгэн байгуулсан сургуульд ажиллаж хөдөлмөрлөж, үйл хэргийг нь үргэлжлүүлж яваадаа баяртай байдаг. Манай Хууль зүйн сургууль 2018 онд байгуулагдсан. Бид орчин үеийн шинэлэг сургалтын орчинг бүрдүүлж, практик дадлагад онцгойлон анхаарч ажилладаг. Тийм ч учраас ахмад туршлагатай багш нартайгаа хамтран чанартай эрхзүйч бэлтгэхийг зорьж байна. Бид хууль зүйн мэргэжилтнүүд бэлтгэхдээ оюутны чанарыг илүүд үзэж, ажлын



байрны бодит шаардлагад нийцсэн мэдлэг, чадвартай боловсон хүчин бэлтгэхийг чухалчилдаг. Сүүлийн жилүүдэд хуулийн чиглэлээр суралцагчдын тоо өсөж, энэ салбар руу орж буй залуусын хүсэл эрмэлзэл нэмэгдэж байна. Ирээдүйд төрийн албанд ажиллах, улстөрийн карьер хөөх хүсэлтэй залууст эрхзүйч мэргэжил зайлшгүй хэрэгтэй.

Төгсгөл нь II нүүрт >>

“СИТИ” ИХ СУРГУУЛИЙН УДИРДЛАГУУД FISU-AUB АЗИЙН ОЮУТНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНЭЭС ХҮРЭЛ МЕДАЛЬ ХҮРТСЭН БАГИЙН ГИШҮҮДИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



FISU-AUB Азийн Оюутны аварга шалгаруулах тэмцээнээс “СИТИ” Их сургуулийн нэр дээр оролцсон Монгол Улсын оюутны шигшээ баг хүрэл медаль хүртсэн билээ.

“СИТИ” Их сургуулийн удирдлагууд тус багийн гишүүдийг хүлээн авч баяр хүргэн, Азийн оюутны спортын холбоо, Тэмцээний зохион байгуулах хороо, Хятадын Тайваны оюутны спортын холбооноос ирүүлсэн “Оролцогчийн диплом”-ыг гардууллаа. Энэ үеэр Монголын оюутны сагсан

бөмбөгийн холбооны тэргүүн О.Тэнүүн Азийн Оюутны аварга шалгаруулах тэмцээнд оролцсон баг тамирчны өмсгөлийг “СИТИ” Их сургуульд дурсгал болгон хадгалуулав.

Дашрамд дурдахад, Азийн Оюутны аварга шалгаруулах тэмцээнд оролцсон баг тамирчдийн дасгалжуулагчаар “СИТИ” Их сургуулийн “Аянга” багийн ахлах дасгалжуулагч Д.Мөнхтүвшин, туслах дасгалжуулагч С.Эрхбаяр нар ажилласан юм.

“ОЮУТНЫ ТАЛБАР”

“СИТИ” Их сургуулийн эрхэм оюутан залуус аа!

“СИТИ” Их сургуулийн эрхэм оюутан залуус та бүхэнд өөрийн үзэл бодлоо олон нийтэд хүргэх, сэтгэн бодох, бичих ур чадвараа нээх гайхалтай боломжийг CITI CAMPUS NEWS олгож байна. Шинэлэг санал санаачилга, сонирхолтой мэдээ мэдээлэл, нийтлэлүүдээ бусдад хүргэхийг хүсч байвал бидэнтэй нэгдээрэй. “СИТИ” Их сургуулийн оюутан бүрт бидний үүд хаалга нээлттэй.

“МАНАЙ БАГШ”

» Түрүүч нь / нүүрт

Тухайн хүн хууль эрхзүйгээ мэддэг, нийгмийн харилцааг ойлгодог байж удирдах албан тушаал болон төрийн албаны ажил гүйцэтгэх чадвартай болно. Эрхзүйн чиглэлээр оройн анги болон магистрын элсэлт авч эхэлсэн нь ажлын хажуугаар суралцах хүсэлтэй хүмүүст боломж олгож буй юм.

-Хуулийн мэргэжил эзэмшсэнээр ямар давуу талтай юм бэ?

-Хуульч хүн бол эмчтэй адил. Эмч хүн биеийн өвчнийг анагаадаг бол хуульч хүн нийгмийн өвчнийг эдгээдэг. Нийгэмд гарч буй аливаа болж бүтэхгүй байгаа зүйлийг цэвэрлэж, шударга, зөв ёс зүйтэй харилцааг бий болгоход чиглэдэг. Хуулийн мэргэжил эзэмшсэнээр хүний ёс зүйг баримтлан, нийгмийн дотоод харилцааг шударга байдлаар зохицуулахад хувь нэмэр оруулна.

-Хуулийн чиглэлээр сурч байгаа оюутнууд юуг илүү чухалчилж үзэх ёстой вэ?

-Хуулийн чиглэлээр суралцаж буй оюутнуудад хамгийн чухал зүйл бол мэдрэмж. Хүн хоорондын харилцааг мэдэрч, ойлгож чаддаг байх нь эрхзүйч хүний чухал шинж чанар. Түүнчлэн онолын гүнзгий мэдлэг эзэмшихээс гадна, түүнийгээ бодит амьдралд ашиглаж сурах чадвар юм. Хууль нь зөвхөн хуурай дүрэм биш, харин бодит амьдралд хүмүүсийн эрхийг хамгаалах, шударга ёсыг хангах зорилготой учраас онолыг зөвхөн цээжлэх биш, ойлгож, хэрэглэхэд суралцах нь чухал. Эрхзүйч гэдэг нь өргөн хүрээтэй ойлголт л доо. Дотроо хуульч, өмгөөлөгч, шүүгч, цагдаагийн ажилтан, прокурорын ажилтан зэрэг олон чиглэлээр нарийвчлан салбарладаг. Оюутан



4 жилийн хугацаанд эрх зүйн мэргэжлийн суурийг эзэмшиж, үүний дараа 2 жил практик дадлага хийж, хуульчийн сонгон шалгаруулалтад орсны дараа өөрийн сонирхсон чиглэлээр мэргэших боломжтой болдог.

-Та оюутнуудад хэрхэн туршлага хуримтлуулах талаар зөвлөөч?

-Эхний алхам бол мэргэжлийн дадлага хийх явдал. Ихэнх хуулийн сургууль оюутнуудад дадлага хийх

боломж олгодог. Энэ бол суралцаж буй мэдлэгээ бодитоор ашиглах, мэргэжлийн орчинд ажиллаж, харилцаа үүсгэх үнэтэй боломж юм. Мөн шүүхийн ажиглалт, хуулийн уралдаан тэмцээн зэрэгт оролцож өөрийгөө сорьж байх хэрэгтэй. Үүнээс гадна, өөрийн мэдлэг, туршлага тэлэхийн тулд хуулийн клуб, судалгааны багт оролцох нь их чухал. Хуулийн чиглэлээр судалгаа хийх нь тун нарийн чадвар шаарддаг.

Оюутнуудад зөвлөхөд, онолын материал уншиж ойлгох, задлан шинжлэх, харьцуулах ур чадвараа хөгжүүлэх нь зүйтэй. Судалгааны эх сурвалжуудыг шалгах, баримтад суурилсан дүгнэлт гаргах нь хуульчийн мэргэжлийн үндсэн чадваруудын нэг юм. Түүнчлэн өөрийн сонирхсон асуудлыг гүнзгий судалж, академик судалгаа хийх дадлага хийхийг зөвлөж байна.

-Хуульч болохоор суралцаж буй оюутнуудын дунд түгээмэл гардаг алдаанууд юу байдаг вэ?

-Ихэнх оюутнууд онолын мэдлэгийг практик дээр хэрэглэх тал дээр учир дутагдалтай байдаг. Зарим оюутан хууль цээжлэхэд хэт анхаарч, бодит амьдралд үүнийгээ хэрхэн ашиглах тал дээр сайн бэлтгэгддэггүй. Мөн хэт өөртөө итгэлтэй байх буюу тухайн мэргэжлийн хариуцлагыг дутуу үнэлэх явдал бас ажиглагддаг. Хуульч болсноор бусдын амьдралд ихээхэн нөлөөлөх учраас мэдлэгтээ үргэлж эргэлзээтэй хандаж, өөрийгөө байнга хөгжүүлж байх хэрэгтэй.

-Таны үед хуулиар сурч байсан оюутнууд болоод өнөөдрийн оюутнуудын хооронд ялгаа бий болов уу?

-Мэдээжийн хэрэг оюутнуудын хооронд ялгаа бий. Миний үед сургалтын орчин, арга зүй, арга барил нь одоогийнхоос өөр байсан. Түүнчлэн ном их уншдаг байлаа. Өнөөгийн оюутнууд орчин үеийн хөгжлийг дагаад цахим хэрэгслүүдийг түлрүү ашиглах болсон. Цахим хэрэгслүүд нь орчин үеийн хөгжлийг дагаж зайлшгүй хэрэгцээтэй боловч, номын гүнзгий мэдлэгийг хэзээ ч орлож чадахгүй гэдгийг санах нь чухал. Оюутнууд ном уншиж, судалгаа хийх дадалтай байх хэрэгтэй.

-Багш хүний бахархал юу вэ?

-Багш хүний хамгийн том бахархал бол оюутнууд нь сурсан мэдлэгээ бодит амьдралд хэрэгжүүлж, нийгэмд шударга ёсыг тогтоохын төлөө тууштай зүтгэж буйг харах мөч юм даа.

-Оюутнууд ирээдүйд хэрхэн амжилт гаргах талаар зөвлөгөө өгөөч?

-Хууль зүйн салбарт амжилттай ажиллахын тулд тэвчээртэй, уйгагүй суралцагч байх нь хамгийн чухал. Мөн тасралтгүй суралцаж, хууль зүйн мэдлэгээ шинэчилж байх хэрэгтэй. Олон улсын хууль зүйн чиг хандлагыг судлах, англи хэлний мэдлэгээ сайжруулах нь мөн ашигтай. Амжилт гаргахын тулд хувийн сахилга бат, харилцааны чадвар маш чухал. Байнга өөртөө өндөр шаардлага тавьж, хариуцлагатай байж, бусадтай итгэлцэлтэй харилцах нь амжилтын үндэс юм. Хууль зүйн салбарт суралцаж буй оюутнууддаа мэргэжлийн ёс зүйтэй, шударга хуульч нар болоорой гэж ерөөе.

О.ЭНХСАРАН



РЕДАКЦЫН ЗУРВАС

Эрхэм оюутан залуус, багш ажилчид, уншигчдадаа энэ өдрийн мэндийг хүргэе. “CITI” Их сургуулийн “CITI CAMPUS NEWS” сонины анхны дугаарыг та бүхэнд өргөн барьж байгаадаа баяртай байна. “CITI CAMPUS NEWS” сонинороо дамжуулан сургуулийн үйл ажиллагааг цаг алдалгүй хүргэх, оюутан, багш нарын дуу хоолойг нийтлэх, шинэлэг санал санаачилга, мэдлэг мэдээллийг хүргэх зорилготой билээ. Энэхүү сонин нь оюутан залуусын бүтээлч үйл ажиллагаа, сургуулийн амьдралын өнгө төрхийг тольдон

харуулахаас гадна, хамтдаа бүтээж буй амжилт, ололтыг хуваалцах чухал гүүр болох юм. Бид анхны дугаартаа “CITI” Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор Ц.Мөнхдэлгэрээс эрх зүйн чиглэлээр суралцаж буй оюутнууддаа зориулж ярилцлага авсан бол, Оюутны лигийн дөрвөн удаагийн аварга “АЯНГА” багийн гишүүн Б.Маргадын сонирхолтой ярилцлага, Урлагийн сургуулийн Эстрада дуулаачийн IV курсийн оюутан, дуучин М.Өлзийсайханы ярилцлага болоод Төгсөгчдийн буландаа Диинид продакшны хамт олныг урьж

оролцууллаа. Түүнчлэн “Ном ярьж өгье” буландаа бид Дашдоржийн Дэмбэрэлцэрэн номыг онцолж, “CITI” Их сургуулийн бүрэлдэхүүн сургуулиудын мэдээ мэдээллийг багтаалаа. Бид цаашдын дугааруудаа улам чамбайруулж, оюутан залуус та бүхний мэдлэг мэдээлэлд хувь нэмэр оруулах зүйлсийг бэлтгэхээр зорьж байна. Шинэ мэдлэг, шинийг эрэлхийлэгч та бүхний сэтгэлд нийцсэн, үр өгөөжтэй сонин байх болно гэдэгт итгэж байна.

“CITI CAMPUS NEWS”
редакцын баг

“CITI CAMPUS NEWS” СОНИНЫ РЕДАКЦ

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ:

“CITI” Их сургууль

ЕРӨНХИЙ РЕДАКТОР:

Б.НОМИН-ЭРДЭНЭ /“CITI” Их сургуулийн маркетингийн менежер/

СЭТГҮҮЛЧ:

Э.БЯМБАСҮРЭН /“CITI” Их сургуулийн Сэтгүүл зүйн IV курсийн оюутан/
Э.СУВД-ЭРДЭНЭ /“CITI” Их сургуулийн Сэтгүүл зүйн IV курсийн оюутан/
О.ЭНХСАРАН /“CITI” Их сургуулийн Сэтгүүл зүйн III курсийн оюутан/
77442244

ХОЛБОО БАРИХ УТАС:

ЦАХИМ ХАЯГ:

Nomin-erdene.bazarragchaa@citi.edu.mn

“БИДНИЙ БАХАРХАЛ”

Б.МАРГАД: СУРГУУЛИАС БИДЭНД БҮХ ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГИЙГ ҮЗҮҮЛДЭГ

» Түрүүч нь / нүүрт

-Энэ багт орсноор мэргэжлийн түвшний дасгалжуулалт авдаг болсон. Сургуулиас заал, гут, фитнес гээд бүх шаардлагатай бололцоог хангаж өгдөг. Түүнчлэн төлбөрийн хөнгөлөлт ч үзүүлдэг.

-Чиний хувьд сагсан бөмбөгийн хамгийн чухал ур чадвар юу вэ?

-Миний бодлоор сагсан бөмбөгт тууштай байдал, тэсвэр тэвчээр, сэтгэл зүй маш чухал гэж боддог. Багийн спорт учраас зөвхөн өөрийн тоглолтоор бус, багийн гишүүдтэйгээ хамтдаа ажиллах нь чухал санагддаг.

-Оюутны лигийн тэмцээнээс авсан хамгийн том сургамж юу вэ?

-Сагсан бөмбөгт амжилт гаргахын тулд зөвхөн техникээс гадна, сэтгэл санаа, бие бялдрын хувьд бэлтгэлтэй байх ёстойг ухаарсан.

-Сагсан бөмбөг сонирхож буй оюутан залууст хандаж юу гэж хэлэх вэ?

-Сагсан бөмбөг гэдэг бол зөвхөн спорт биш, хичээл зүтгэл, хариуцлага, хамтын ажиллагаа гэдгийг хэлмээр байна.

-Сагсан бөмбөгөөс үлгэр дууриал



авдаг ямар тамирчин байдаг вэ?

-Олон шилдэг тамирчид бий ч, Kobe Bryant-ын тоглолтуудыг үзэж үлгэр дууриал авдаг даа.

-“АЯНГА” багт тоглох хүсэлтэй

оюутнууд олон байдаг байх?

-Тэгэлгүй яхав. Манай багт элсэх хүсэлтэй олон оюутан ирж, өөрсдийн ур чадвараа шалгуулдаг. 12 дугаар ангиа төгсөөд шууд л “СИТИ”

Их сургуульд орно гээд зорилго тавьчихсан хүүхдүүд ч ирдэг.

Э.СУВД-ЭРДЭНЭ



СИТИ “АЯНГА” БАГИЙН 2024.11.06–11.30–НИЙ ӨДРИЙН ТОГЛОЛТЫН ХУВААРЬ

2024.11.08 БААСАН ШУТИС СПОРТ ЗААЛ

18:00 ЭЗШУИС MONOS DUCKS VS СИТИ ИС АЯНГА–2

2024.11.10 НЯМ НААДАМ ТӨВ СПОРТ ЗААЛ

19:30 СИТИ ИС АЯНГА VS ОТИС ШИЛҮҮСНҮҮД

2024.11.13 ЛХАГВА ЭТҮГЭН СПОРТ ЗААЛ

14:00 ОМНИ ЭТҮГЭН ИРВЭСҮҮД ЭМ VS СИТИ ИС АЯНГА ЭМ

2024.11.16 БЯМБА НААДАМ ТӨВ СПОРТ ЗААЛ

13:30 МГТИС ХАРААЦАЙНУУД VS СИТИ ИС АЯНГА–2

2024.11.17 НЯМ НААДАМ ТӨВ СПОРТ ЗААЛ

18:00 СИТИ ИС АЯНГА VS ШУТИС ШАРКС–2

2024.11.23 БЯМБА НААДАМ ТӨВ СПОРТ ЗААЛ

19:30 СИТИ ИС АЯНГА VS СЭЗИС

2024.11.24 НЯМ НААДАМ ТӨВ СПОРТ ЗААЛ

13:30 СИТИ ИС АЯНГА–2 VS ОТИС ШИЛҮҮСНҮҮД–2

2024.11.30 БЯМБА НААДАМ ТӨВ СПОРТ ЗААЛ

09:00 ГЛОБАЛ УДИРДАГЧ ИС VS СИТИ ИС АЯНГА–2

16:30 СИТИ ИС АЯНГА ЭМ VS ИХ ЗАСАГ–ЧИНГИС СООСЭ ЭМ

2024.12.01 НЯМ НААДАМ ТӨВ СПОРТ ЗААЛ

18:00 СИТИ ИС АЯНГА VS МУБИС БУГАНУУД

АНУ-ЫН 47 дахь Ерөнхийлөгчөөр ДОНАЛЬД ТРАМП сонгогдлоо



Америкийн Нэгдсэн Улсын 47 дахь удаагийн Ерөнхийлөгчийн сонгууль болж, Бүгд найрамдах намаас нэр дэвшигч Доналд Трамп ялалт байгууллаа. Тэрээр ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөхдөө Америкчуудыг “Дахин томоор мөрөөд” хэмээн уриалсан юм. Өдгөө 78 настай Дональд Трамп 2016-2020 оны хооронд АНУ-ын 45 дахь ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байсан билээ. Тэрээр 2025 оны нэгдүгээр сард тангараг өргөх юм. Дэлхийн анхаарлын төвд байсан АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд манай улс ч мөн тодорхой түвшинд ач холбогдол өгч оролцов. Монгол Улс дахь АНУ-ын ЭСЯ-аас сонгууль ажиглах өдөрлөг зохион байгуулсан юм. Өдгөө манай гуравдагч хөрш болох АНУ-д 30 гаруй мянган монголчууд ажиллаж, амьдарч байна.

АНУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТАЛААР ХЭН, ЮУ ХЭЛЭВ?



АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Ричард Буанган: Сонгуулийн үр дүнгээс манай хоёр орон цаашид юун дээр төвлөрч ажиллах нь тодорхой болно.

Дүн ямар гарахаас үл шалтгаалан АНУ Монголын ард түмэнтэй тогтоосон иргэд хоорондын харилцаандаа тууштай байх болно. Сонгуулийн үр дүнгээс шалтгаалж манай хоёр орон юун дээр төвлөрч ажиллах нь тодорхой болох байх. Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалтын орчинд байгаа

тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, дотоод болон гадаадын хөрөнгө оруулалт хийх таатай нөхцөлийг бүрдүүлэхэд хамтран ажиллана гэж найдаж байна. Монгол Улс, АНУ-ын харилцаа бат бэх хэвээр байгаа ба засаг захиргаа солигдсон ч бат бөх хэвээр байдаг туйлын таатай байдаг. Хоёр улсын харилцаа сүүлийн 30 жилийн хугацаанд тасралтгүй өсөн нэмэгдсээр ирсэн. Иргэд хоорондын төдийгүй худалдааны харилцаа ч өргөжсөөр байгаа. Тиймээс хоёр орны харилцаа илүү ойр дотно болно гэдгийг итгэлтэй хэлж чадна.



Олон улсын харилцааны судлаач, профессор Д.Баярхүү: Трамп АНУ, Монголын харилцаанд гавьяа байгуулсан хүн.

Трамп өмнө нь ерөнхийлөгч байхдаа Монгол-Америкийн харилцаанд өөрийнхөө үүргийг гүйцэтгэсэн. Хоёр орны харилцаанд гавьяа байгуулсан, ул мөрөө үлдээсэн хүн. Стратегийн түншлэл тогтоосон нь түүний гавьяа. 2018 онд У.Хүрэлсүх Ерөнхий сайд байх үедээ АНУ-д айлчлаад Монгол-Америкийн харилцааг түншлэлийн

нэг шатаар ахиулсан. 2004 оноос Иж бүрэн түншлэлийн харилцаатай явж ирсэн бол 2018 онд өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн харилцаатай болсон. Түүний дараа 2019 онд буюу жил хүрэхгүй хугацаанд хоёр улс стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон. Нэг жилийн хугацаанд хоёр өндөр түвшний харилцаа тогтоолгож чадсан хүн бол Трамп байсан. Энэ харилцаа цаашид үргэлжилнэ, шинэ шатанд гарна гэж итгэж байна.

“НОМ ЯРЬЖ ӨГЬЕ”

ДАШДОРЖИЙН ДЭМБЭРЭЛЦЭРЭН



Энэхүү ном нь Монгол Улсын хууль зүйн түүхэн замналыг хүүрнэн өгүүлэхдээ, түүхэн шилжилтийн үед чухал үүрэг гүйцэтгэсэн нэрт хуульч, Дээд шүүхийн дарга асан Д.Дэмбэрэлцэрэнгийн амьдрал, ажлын замналыг харуулсан бүтээл юм. Түүний амжилт, хувь хүний намтар нь нийгмийн эрх чөлөө, хүний эрхийг хамгаалах, шударга ёсыг баталгаажуулахад үнэтэй хувь

нэмэр оруулсан төдийгүй орчин үеийн Монголын шинэ Үндсэн хуулийн үзэл санааны тулгуур болжээ. 1992 онд батлагдсан ардчилсан шинэ Үндсэн хууль нь хүний эрх, шударга ёсыг хамгаалах үндсэн зарчимтай байсан бөгөөд Д.Дэмбэрэлцэрэн агсан энэ зарчмуудыг нийгмийн амьдралд гүнзгий шингээх, хууль зүйн салбарыг шинэчлэхэд тууштай зүтгэж иржээ. Түүнд Монгол Улсын шилжилтийн үеийн хуулийн шинэчлэлийг удирдан чиглүүлэх хувь заяа оногдож. Монголын хууль зүйн уламжлал, шинэчлэлийн үйл явцтай сүлэлдсэн түүний замнал бол хувь хүний намтрыг хальж, нийгмийн бодит эх сурвалж болсон юм. Энэхүү бүтээл нь уншигчдад Монгол Улсын хууль зүйн түүхэн замнал, түүний туулсан ээдрээтэй чухал үе шатууд, мөн иргэний эрх, тэгш байдал, шударга ёсыг дээдэлсэн Монголын шинэ үнэт зүйлсийг ойлгоход хөтлөх болно. Хойч үедээ үнэт сургамж үлдээх энэхүү ном нь зөвхөн Д.Дэмбэрэлцэрэнгийн намтар бус, Монголын ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг бий болгож, баталгаажуулахын төлөө тэмцэж ирсэн түүхийг ч өгүүлэх юм.

“ОЛОН УЛСЫН ОЮУТНЫ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР”



Чехийн эх оронч оюутнуудын дурсгалд зориулан 1946 оны арваннэгдүгээр сарын 17-ны өдөр Прага хотноо зохион байгуулсан Дэлхийн оюутны бага хурал дээр энэ өдрийг “Олон улсын оюутны эрхийг хамгаалах өдөр” болгон тэмдэглэж байхаар тогтоожээ.

1939 оны аравдугаар сарын 28-нд фашистуудад бүслэгдсэн Чехословакт Прагийн оюутан залуус багш нарын хамт 1918 оны аравдугаар сарын 28-нд Чехословакийн төрт Улс байгуулагдсаны ойг тэмдэглэн жагсжээ. Бүслэлтийн суман жагсагчдыг хүчээр тараах үедээ Анагаахын факультетын оюутан Ян Оплеталыг буудан хороожээ. Ян Оплеталын оршуулгын үеэр эсэргүүцлийн жагсаал хүчээ авч олон жагсагчид баривчлагдсан

байна. Арваннэгдүгээр сарын 17-ны өглөө фашистуудад оюутны дотуур байруудыг бүсэлж, 1200 гаруй оюутныг баривчлан Заксенхаузен дахь хорих лагерьд аваачжээ. Хөдөлгөөний есөн гишүүн оюутныг Прагийн Рузин дүүргийн шоронд шударга шүүхгүйгээр шийтгэжээ. Энэ явдлын дараа Чехийн дээд боловсролын бүх байгууллагыг Гитлерийн тушаалаар дайн дуусах хүртэл хаасан түүхтэй. Жил бүрийн арваннэгдүгээр сарын 17-нд дэлхийн олон оронд энэ өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг байна.

“СИТИ” Их сургуулийн шинийг эрэлхийлэгч, шилдэгт тэмүүлэгч оюутан залуустаа “Олон улсын оюутны эрхийг хамгаалах өдөр”-ийн баярын мэнд хүргэе.

“CITI БРЭНД”



Оюутнууд, төгсөгч, багш ажилтан та бүхэнд СИТИ Их сургуулийн нэрийн бүтээгдэхүүнүүдийг санал болгож байна. Сургуулийнхаа бахархлыг илэрхийлэх нэрийн брэнд бүтээгдэхүүнүүдийг та бүхэн “СИТИ” Их сургуулийн А байрны 2 давхарт байрлах нэрийн брэнд дэлгүүр (Merchandise concept store) -ээс худалдан авах боломжтой. Түүнчлэн халуун кофе, шинэхэн зайрмагийг ч таньд санал болгож байна.




БОЛОВСРОЛЫН ТҮВШИН ӨСӨХ ТУСАМ ОРЛОГО ӨСДӨГ

Тааруу сурдаг хүүхдүүд сайхан амьдардаг, мөнгө их олдог. Манай ангийн гавал тааруухан амьдарч байна гэх мэт ойлголт манайд хүчтэй явдаг. Харамсалтай тийм зүйл байхгүй гэдгийг олон судлаачид судлаад тогтоочихжээ. Боловсролын түвшин өсөх тусам орлого нь өсдөг. <https://www.bls.gov/.../data-on-display/education-pays.htm> Доктор зэрэгтэй хүн дипломгүй хүнээс гурав дахин их цалинтай. Дунд сургуульдаа онц сурдаг хүүхдүүд илүү их орлого олдог

<https://phys.org/.../2014-05-high-school-gpa-affect...> Манайхан маргахаараа онцгой дахин давтагдахгүй ховор хүмүүсийг дурддаг. Тийм хүн тэрбум хүнд 2-3 л төрнө. Нас ахиад хэл сайн сурсан хүн байдаг. Жишээ нь: Ренчин гуай. Ренчин гуай дахин давтагдахгүй. Facebook, Tesla, Microsoft байгуулсан хүмүүс их сургууль төгсөөгүй гэх. Эд нар бас онцгой ховор хүмүүс. Энэ хүмүүст Facebook, Tesla, Microsoft хийх санаа, хэрэгжүүлэх

чадвар байсан. Онцгой ховор үзэгдлээр жишээ авахаа болиод хүмүүсийн судлаад гаргаад ирсэн давтагддаг зүйлийг ярьцгаая. Цукерберг их сургууль төгсөөгүй гэж хүүхдийг сумлаж болох ч тэр хүүхэд Цукерберг шиг болох магадлал ~0.00000001% буюу бараг боломжгүй. Тиймээс оюутнуудаа хичээлээ сайн хий.

Source: <https://www.facebook.com/ganbat.baasantseren>



“CONGRATULATIONS”



“MBEAU 2024 INTERNATIONAL BEAUTY COMPETITION” олон улсын тэмцээнд “СИТИ” Их сургуулийн багш, оюутнууд амжилттай оролцож 10 гаруй медаль хүртлээ.



Багш Г.Гандиймаа “WORLD K-BEAUTY FESTIVAL-2024” тэмцээнээс хос мөнгөн медаль хүртлээ.



Гоо сайхны олимп буюу “OMC HAIRWORLD” тэмцээнд “СИТИ” Их сургуулийн Гоо сайхны ухааны сургуулийн багш Л.Маралмаа Creative make up - III байр, хүрэл медаль, Stage make up - IV байр, Үсчин стилистийн багш Э.Уянга Эмэгтэй урт үсний хуримын самналт -Тусгай байр, Ази, Америк, Европ тивийн аварга шалгаруулах “CONTINENT CUP” тэмцээний “LADIES CREATIVE COLOR” төрөлд I байр эзэлсэн цомоо тус тэмцээний үеэр гардан авлаа.



“Улаанбаатар 2024” хөгжөөн дэмжигчдийн спортын улсын аварга шалгаруулах тэмцээнд “СИТИ” Их сургуулийн “Ситара” багийн тамирчид U18 насны ангилалд “Гутгаар байр”, их, дээд сургуулиудын ангилалд “Дэд байр” эзэллээ.



“СИТИ” Их сургуулийн Гоо сайхны ухааны сургуулийн мэргэжлийн нүүр хувиргалтын ахлах багш Г.Хос-Эрдэнэ 16 дахь удаагийн Улаанбаатар олон улсын кино наадмаас “Үхлийн тойрог” киноны нүүр хувиргалтаараа “Шилдэг нүүр хувиргагч”-аар шалгарлаа.

БАГШ М.БЯМБАСҮРЭН ГАЗАРЗҮЙ, ГЕОЛОГИЙН САЛБАРЫН “ХҮРЭЛТОГООТ-2024” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ШИЛДЭГ СУДЛААЧИЙН НЭГЭЭР ТОДОРЛОО



Эдийн засаг, хөгжлийн яам, Шинжлэх ухааны академи, Шинжлэх ухаан, технологийн сан, Монголын залуу эрдэмтдийн холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Хүрэлтогоот 2024” эрдэм шинжилгээний хуралд Газарзүй, геологийн салбар хуралдаанд “СИТИ” Их сургуулийн Бизнесийн сургуулийн Аялал жуулчлалын тэнхимийн эрхлэгч М.Бямбасүрэн шилдэг 10 оролцогчийн нэг боллоо.



“СИТИ” Их сургууль 11 дүгээр сарыг багш, ажилчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих сар болгон зарлалаа. 11 дүгээр сарын турш багш, ажилчдын сэтгэл зүйн эрүүл мэндэд анхаарал хандуулж, дэмжлэг үзүүлэх олон талт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх юм. Сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих нь үр дүнтэй ажиллах, ажилчдын сэтгэл

санааг сайжруулах, нийгэмд эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилготой. Багш, ажилчдын амьдралд үүсч болох сэтгэл гутрал, стрессийг багасгах, түүнд анхаарал тавьж, дэмжих нь оюутнуудын сургалтын амжилт болон хамт олны дундах эерэг уур амьсгалыг бий болгоход чухал нөлөөтэй юм.

М.ӨЛЗИЙСАЙХАН: СУРГУУЛЬДАА ОРЖ ИРСЭН АНХНЫ ӨДРӨӨ Л ОЮУТАН НАС ГЭЖ ҮҮНИЙГ Л ХЭЛДЭГ БАЙХ ГЭХ ГАЙХАЛТАЙ МЭДРЭМЖИЙГ АВСАН

“СИТИ” Их сургуулийн Урлагийн сургуулийн Эстрад дуулаачийн IV курсийн оюутан М.Өлзийсайхантай ярилцлаа. Тэрээр 2017 онд Хөгжмийн зохиолч О.Эрдэнээгийн аялгуу, дуучин О.Гансүвдэн дуулсан “Миний ээж хөөрхөн” дууг хэн сайн дуулах вэ уралдаанд оролцож, тэргүүн байрт шалгарч байсан билээ. Өдгөө тэрээр олон сайхан дууг дуулж амьдруулсан байна.



-Багаасаа дуулах дуртай, дуунд хайртай хүүхэд байв уу?

-Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Юуны өмнө надаас ярилцлага авч байгаад баярлаж байна. Би багаасаа дуунд дуртай, дуулдаг, бүжиглэдэг, шүлэг уншдаг хүүхэд байсан. Тийм ч учраас өдгөө хүссэн мэргэжлээрээ сураад явж байна.

-“СИТИ” Их сургуультай хэрхэн холбогдов оо?

-“СИТИ” Их сургууль нэр хүндтэй, чадварлаг багштай, төгсөгчид нь карьертай. “СИТИ” Их сургуульдаа би шилжин ирж, Урлагийн сургуулийн Эстрад дууны ангид С.Алтан-Уяа багшийнхаа удирдлага дор суралцаж байна. Би сургуульдаа орж ирсэн анхны өдрөө л оюутан нас гэж үүнийг л хэлдэг байх гэх гайхалтай мэдрэмжийг авсан. IV курсийн оюутан болохоор хавар төгсөлтийн баяр дээрээ энэ гоё мэдрэмжээ илэрхийлнэ гэж бодож байгаа.

-Оюутны нэг өдөр чинь хэрхэн өнгөрдөг вэ?

-Миний нэг өдөр бусдын л адил өнгөрдөг дөө. Хичээлдээ явна. Найз нөхөдтэйгөө уулзана гээд л.

Мөрөөдөлдөө хөтлөгдөж сэрдэг өдөр маань мягмар, баасан гаригууд. Учир нь би энэ хоёр өдөр мэргэжлийн хичээлтэй байдаг юм. Мэргэжлийн хичээл орохоор үнэхээр сэтгэл сэргэдэг. Миний мэргэжилдээ дурлах олон шалтгааны нэг нь багш маань байгаа юм. Энэ дашрамд С.Алтан-Уяа багшдаа баярлаж явдгаа хэлмээр байна.

-Ямар төрлийн дууг дуулж үзэхсэн гэж боддог вэ?

-Мэргэжлийнхээ дууг л илүү сайн дуулж, мэргэжлээ маш сайн эзэмших юмсан гэж боддог доо.

-Ирээдүйн төлөвлөгөө, зорилго юу вэ?

-Сэтгэл зүрх, цаг заваа зориулж бидний төлөө байдаг багшийнхаа итгэлийг алдахгүй, заасан бүхнийг нь сайн сурч, сайн дуучин болох мөрөөдөлтэй.

Э.БЯМБАСҮРЭН

CITI NEWS


“БАГШ, СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ” БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДЛЭЭ



“СИТИ” Их сургуулийн бүрэлдэхүүн Хүмүүнлэгийн сургуулийн Боловсрол судлалын тэнхимийн “Багш, сургуулийн өмнөх боловсрол” бакалаврын хөтөлбөр 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдлээ. Ийнхүү “Цэцэрлэгийн багш”

мэргэжлээр суралцах оюутнууд 100 хувь тэтгэлэгт хамрагдах боломжтой болсныг дуулгахад таатай байна. Хүүхдийн хөгжилд хувь нэмрээ оруулах чин хүсэлтэй оюутан, залуус та бүхэнд амжилт хүсье.

ШААЛУУ ХҮҮ “МАУГЛИ” ПЛАСТИК ЖҮЖИГ ТОГЛОГДОНО



“СИТИ” Их сургуулийн Урлагийн сургуулийн Жүжиглэх урлагийн тэнхимийн IV курсийн оюутнууд ирэх сарын 10-нд РЦНК-ийн тайзнаа

Шаалуу хүү “МАУГЛИ” пластик жүжгийг толилуулах гэж байна. Та бүхнийг урьж байна.



Аялал жуулчлалын тэнхимийн дэргэдэх “Urban Adventure” клуб 2024-2025 оны хичээлийн жилийн анхны аяллаа Сэлэнгэ аймгаас эхлүүлээ.



“СИТИ” Их сургуулийн багш, оюутнуудад Усны газрын дарга, доктор /Ph.D/ З.Батбаяр “Дусал бүр үнэ цэнэтэй” сэдвээр лекц уншлаа.



“СИТИ” Их сургуулийн Хүмүүнлэгийн сургуулийн Боловсрол судлалын тэнхимийн Сэтгэл судлалын багш, докторант Ж.Айганым “Сэтгэлзүйн тогтвортой байдалд стрессийн хүчин зүйл нөлөөлөх нь” сэдвээр багш, ажилчдад лекц тавилаа.



“СИТИ” Их сургуулийн Гоо сайхны ухааны сургуулийн оюутнуудын жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ГОО САЙХАН-ЭРҮҮЛ ХООЛ 2024” өдөрлөг амжилттай болж өнгөрлөө.

CITY СПОРТ

“СИТИ” ИХ СУРГУУЛИЙН “СПОРТЫН ИХ НААДАМ” БОЛЛОО

“СИТИ” Их сургуулийн оюутнуудыг биеийн тамир, спортоор хичээллэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг оюутны “СПОРТЫН ИХ НААДАМ” /2024.10.18,19/-ний өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө.

**“САГСАН БӨМБӨГИЙН АВАРГА”****ШИЛЖИН ЯВАХ ЦОМ:**

Бизнесийн сургуулийн баг

ЭРЭГТЭЙ БАГ ТАМИРЧИД:

Алт - Урлагийн сургуулийн шигшээ баг

Мөнгө - Бизнесийн сургуулийн IV баг

Хүрэл - Бизнесийн сургуулийн I баг

ЭМЭГТЭЙ БАГ ТАМИРЧИД:

Алт - Бизнесийн сургууль

Мөнгө - Хүмүүнлэгийн сургууль

Хүрэл - Бизнесийн сургуулийн Агаарын тээвэр

ШИЛДЭГ ЭРЭГТЭЙ ТОГЛОГЧ:

Н.Тэмүүжин, /Хүмүүнлэгийн сургууль/

ШИЛДЭГ ЭМЭГТЭЙ ТОГЛОГЧ:

А.Анужин, /Бизнесийн сургууль/

ЭРЭГТЭЙ АЛСЫН ЗАЙН ШИДЭЛТИЙН АВАРГА:

Б.Энэрэл, /Хүмүүнлэгийн сургууль/

ЭМЭГТЭЙ АЛСЫН ЗАЙН ШИДЭЛТИЙН АВАРГА:

М.Тэлмүүнээ /Бизнесийн сургууль/ нар тус тус шалгарлаа.



Мөн “ШАТАР, ДААМНЫ АВАРГА” шалгаруулах тэмцээн аравдугаар сарын 25-ны өдөр амжилттай болж өндөрлөлөө.

Дараах оюутнууд шагналт байранд шалгарлаа.

ШАТАР:

I байр – Х.Шижирболд (Дуурийн дуулаач IV курс);

II байр – Э.Арсай (Жүжиглэх урлаг I курс);

III байр – С.Хаш-Эрдэнэ (Эрх зүй III курс);

ДААМ:

I байр - Л.Алтанхуяг (Гоо сайхны ухааны сургуулийн сувилахуйн тэнхимийн багш);

II байр - Б.Номин-Эрдэнэ (Дизайн III курс);

III байр – О.Алтангэрэл (Дизайн II курс) нар тус тус шалгарлаа.



ТӨГСӨГЧДИЙН АМЖИЛТЫН ТҮҮХ

Э.ТОДБАЯР: БИД СУРГУУЛИАС ОЛЖ АВСАН МЭДЛЭГ ЧАДВАР, БАГШ НАРЫНХАА АЧААР ӨДИЙ ЗЭРЭГТЭЙ ЯВАА ГЭЖ БОДДОГ



“СИТИ” Их сургуулийн төгсөгч “Диинид” продакшныг үүсгэн байгуулагч, жүжигчин Э.Тодбаяртай ярилцлаа.

кино драмын ангийг МУГЖ С.Өлзийхүү багшийн удирдлага дор Н.Болдбаатар дүү маань төгссөн.

Ийм таван гишүүнтэйгээр Диинид продакшндаа ажиллаж байна даа.

-Сургуулиас авсан мэдлэг, ур

чадвар мэргэжил дээр хэрхэн тусалсан бэ?

-Хамгийн чухал нь л энэ. “СИТИ” Их сургуулиас олж авсан мэдлэг чадвар, мундаг багш нарынхаа ачаар л бид өдий зэрэгтэй яваа гэж боддог. Сургуульдаа ч маш их баярладаг. Учир нь маш сайн багш нараар бидэнд хичээл заалгадаг. Манай Хөдөлгөөний багш Ганбаатар, Билгүүн багш, Дууны багш Оюунчулуун гээд үнэхээр шилдгүүд бидэнд хичээл заадаг байлаа шүү дээ. Багш нарын маань бидэнд зааж сургасан бүхний ачаар өнөөдөр үзэгчдэдээ үнэлэгдээд явж байна гэж боддог доо.

-Сургуулийн амьдралаас хамгийн дурсамжтай мөч тань юу вэ?

-Оюутны амьдралын бүх зүйл л дурсамжтай. Хоолоо хувааж идэхээс эхлээд л. Жүжигчний анги чинь өглөөнөөс эхлээд орой хүртэл хичээлээ үзнэ, бэлтгэлээ хийнэ. Үргэлж л хамт байна шүү дээ. Нэг л хүн байхгүй бол тэр хичээл, тэр бэлтгэл сургуулилт явдаггүй. Өдөр бүр инээд хөөр, дуу шуутай өнгөрнө. Ялангуяа жүжигчний анги бол инээд салахгүй л өдрүүд байдаг.

-Ямар хичээл, ямар багш танд хамгийн их нөлөөлсөн бэ?

-Энэ багш, энэ хичээл илүү нөлөөлсөн гэж ярих өрөөсгөл байх. Яг онцолж хэлнэ гэвэл мэргэжлийн багш, тайзны ярианы багшаа хэлэх болов уу. Гэхдээ бүх л хичээл маань уялдаа холбоотойгоор мэргэжил маань гардаг.

-Продакшндаа шинэ санаа, бүтээлч шийдэл гаргахад юу тус болдог вэ?

-Бидний ямар нийгэмд амьдарч байна, нийгмийн эмзэглэл юу байна гэдгийг эхлээд хардаг. Оюутан байх хугацаандаа уншиж байгаа ном зохиолоосоо сэдэв олж харна. Үүнийг л хүмүүст хүргэе гэж бодно, төлөвлөнө. Юуг яаж дуугарвал нийгэмд сонирхолтой бол гэдэг талаас нь харж уран бүтээлээр хэлэх гэж зорьдог доо.

-Продакшныхаа ирээдүйг хэрхэн харж байна. Хийхээр төлөвлөж буй томоохон төсөл байгаа юу?

-Бид анх кино хийх зорилготойгоор продакшнаа байгуулсан. Хэн ч танихгүй залуучуудын киног санхүүжүүлнэ, дэмжинэ гэж байдаггүй юм билээ л дээ. Тэгээд бид өөрсдийгөө эхлээд таниулъя гэж шийдсэн. Ийм хүсэл зорилго, тэмүүлэлтэй залуучууд байгаа шүү гэдгээ таниулах үүднээс социал контентийг хоёр жил тасралтгүй хийж хийж иржээ. Одоо бид томоохон кино уран бүтээлд орох төлөвлөгөөтэй ажиллаж байна. 12 сарын 3-наас IPT сувгаар цацагдах шинэ жилийн киноны зураг авалт эхлээд явж байна.

-Өнөөгийн залууст карьерт хэрхэн амжилт гаргах талаар зөвлөгөө өгөөч?

-Аливаа зүйлд тууштай байгаарай гэж хэлбэ.

-Та бүхэн Диинид продакшныг үүсгэн байгуулаад явж байна. Фээсбүүк пэйж дээрээ олон үзэгч, дагагчтай болжээ. Оюутан байхдаа продакшнаа байгуулж байсан гэсэн. Тухайн үед яаж эхэлж байв. Түүх сөхвөл?

-Бид гуравдугаар курст байхдаа ангийнхнаараа нэгдэж, Диинид продакшнаа байгуулсан. Энэ хугацаанд театрт ажиллах нь ажиллаад, зарим нь хувийн уран бүтээлээ хийгээд, шантрах нэг нь шантраад, эцэст нь бид дөрөв хамтдаа үлдэж, “Диинид” продакшндаа уран бүтээлээ үргэлжлүүлж байна. Э.Ариун-Эрдэнэ, Г.Билгүүн, Ж.Ямраанз бид дөрөв 2021 онд “СИТИ” Их сургуулийн кино драмын ангийг МУГЖ Ц.Төмөрхуяг, СТА Б.Эрдэнэцэцэг багшийн удирдлага дор сурч төгссөн. Харин 2023 онд “СИТИ” Их сургуулийн

